



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/40

Сант сум

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 22,24 дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 28.1.3, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.6, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, 7.10, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Ноёны бууц” ББН –ийн “Сант” дэлгүүрт хуулийн дагуу утаат тамхи худалдаалах зөвшөөрлийг 2023 оны 05 дугаар сарын 10-ний өдрөөс эхлэн 3 / гурав/ жилийн хугацаатай олгосугай.

2.Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлд тавигдах шаардлагыг хангаж, 7.10 дахь заалтад заасан баримт материалын бүрдэлийг хангаж ажиллахыг “Ноёны бууц” ББН дэлгүүрийн эзэн (А.Оюунтунгалаг)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүнс, Жижиг дунд үйлдвэр, худалдаа, хоршооны асуудал хариуцсан мэрэгжилтэн (Ж.Оюунбат)-д даалгасугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *М. Оюунбаяр*
Хянасан: *В. Дундговь*
Хувь: *д*